

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/83/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:Erdeneb@audit.gov.mn">Erdeneb@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn">Enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:enkhturb@audit.gov.mn">enkhturb@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
  4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
  6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.13 № 47

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН АЙМГИЙН ТЭШИГ  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
С.СҮНЖИДМАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуульд боловсролын байгууллага гэж заагаагүй тул тус хууль бүрэн хамааралтай.

Тус байгууллага нь бичиг хэргийн зардлыг өмнөх онтой харьцуулахад 2.4 сая төгрөгөөр хэмнэлт үүсгэж, 11 удаагийн сургалт семинарыг цахимаар зохион байгуулж үүнээс албан томилолтын зардал, шатахууны зардлыг хэмнэж ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч

006020051

үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

МУ-ын БШУ-ны Сайдын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/494 тушаалын дагуу цахим анги тохижуулах "Хүүхдэд ээлтэй орчин" Тендер зарлаж "Тех но зон" ХХК шалгарч 0.9 сая төгрөгийн үнэтэй Tab8 25 ширэг, Notebook 2 ширхэг 5.9 сая, суурин компьютер 1 ширхэг 3.2 сая, Ухаалаг самбар 9.9 сая төгрөгөөр цахим дэлгүүрээс худалдан авалт хийжээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2022 онд 8 зорилтын хүрээнд 33 ажил төлөвлөж гүйцэтгэлийн биелэлт 96.8 хувьтай дүгнэгджээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>148,919,791.21</b>	<b>222,137,191.96</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	78,888,263.75
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	78,888,263.75
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	78,888,263.75
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	78,888,263.75
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	135,919,791.21	143,248,928.21
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	135,619,791.21	142,948,928.21
35410	Бичиг хэргийн материал	4,413,463.74	4,510,907.74
35420	Аж ахуйн материал	96,534,344.13	97,221,494.13
35460	Хүнсний материал	3,027,880.50	11,458,815.50
35470	Бусад хангамжийн материал	29,894,102.84	29,757,710.84
35600	Мал амьтад	300,000.00	300,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,003,811,029.12</b>	<b>2,008,712,318.05</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,003,811,029.12	2,008,712,318.05
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,911,447,589.12	1,921,445,318.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,886,642,677.23	1,886,642,677.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	(99,220,415.74)	(149,283,453.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	117,497,390.24	191,593,316.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(84,301,556.49)	(103,321,275.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	134,636,367.97	146,532,935.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(63,031,409.28)	(77,261,924.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,354,038.70	4,758,940.00
39217	Ном	8,870,496.49	21,784,102.19
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	92,363,440.00	87,267,000.00
39301	Програм хангамж	1,600,000.00	1,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(337,500.00)	(675,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	91,100,940.00	86,342,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,152,730,820.33</b>	<b>2,230,849,510.01</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>584,109.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	584,109.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	584,109.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	584,109.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,152,730,820.33</b>	<b>2,230,265,401.25</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,152,730,820.33	2,230,265,401.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,003,170,165.12	1,003,170,165.12
51101	Өмч: - төрийн	1,003,170,165.12	1,003,170,165.12
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	851,444,636.19	928,979,217.11
51210	Өмнөх үеийн үр дүн	851,444,636.19	851,444,636.19
51220	Тайлант үеийн үр дүн	-	77,534,580.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	298,116,019.02	298,116,019.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,152,730,820.33</b>	<b>2,230,849,510.25</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

## САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,227,584,266.75</b>	<b>1,640,108,141.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,980,635.15</b>	<b>33,441,741.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	9,980,635.15	33,441,741.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	354,500.00	2,621,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,051,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	570,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	8,663,130.75	30,819,941.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,216,603,631.60</b>	<b>1,606,666,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,013,474,100.00	1,279,330,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,279,330,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	201,591,549.60	327,336,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	201,591,549.60	327,336,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,291,212,618.62</b>	<b>1,562,573,560.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,291,212,618.62</b>	<b>1,562,573,560.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,235,395,874.76	1,442,412,766.15
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	783,985,389.36	919,679,551.00
210101	Үндсэн цалин	525,787,388.36	674,765,585.00
210102	Нэмэгдэл	193,904,380.00	199,590,529.00
210104	Урамшуулал	64,293,621.00	45,323,437.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	103,101,780.18	116,112,167.97
210201	Тэтгэврийн даатгал	72,593,594.53	79,969,067.48
210202	Тэтгэмжийн даатгал	7,621,294.68	9,386,701.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,115,156.55	6,954,765.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,524,839.52	1,773,718.63
210205	Эрүүл мэндийн даатгал	15,246,894.90	18,027,914.24
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	200,841,549.60	218,462,551.75
210301	Гэрэл, цахилгаан	6,355,405.00	12,067,900.00
210302	Түлш, халаалт	185,285,760.00	184,821,360.00
210303	Цэвэр, бохир ус	9,200,384.60	21,573,291.75
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,292,156.40	979,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,535,550.00	979,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	24,546,465.20	51,903,558.60
210502	Хоол, хүнс	20,737,265.20	51,903,558.60
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,717,500.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,164,500.00	1,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	605,000.00	6,730,200.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	605,000.00	913,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,816,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>108,477,834.02</b>	<b>127,545,436.83</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,482,800.00	25,770,059.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,644,780.00	18,124,606.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,350,254.02	83,650,771.83
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,816,743.86</b>	<b>120,160,793.93</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,381,162.90</b>	<b>67,114,798.80</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,781,162.90	67,114,798.80
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>53,045,995.13</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	53,045,995.13
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(63,628,351.87)</b>	<b>77,534,580.92</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(63,628,351.87)</b>	<b>77,534,580.92</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,219,285,837.60</b>	<b>1,609,288,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,682,206.00</b>	<b>2,621,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,682,206.00</b>	<b>2,621,800.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>354,500.00</b>	<b>2,621,800.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,051,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	570,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,216,603,631.60</b>	<b>1,606,666,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,013,474,100.00</b>	<b>1,279,330,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,279,330,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>201,591,549.60</b>	<b>327,336,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	201,591,549.60	327,336,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,203,054,837.60</b>	<b>1,485,667,816.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,203,054,837.60</b>	<b>1,485,667,816.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,147,533,716.14</b>	<b>1,358,251,971.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>783,985,389.36</b>	<b>919,679,551.00</b>
210101	Үндсэн цалин	525,787,388.36	674,765,585.00
210102	Нэмэгдэл	193,904,380.00	199,590,529.00
210104	Урамшуулал	64,293,621.00	45,323,437.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>103,101,780.18</b>	<b>116,112,167.97</b>
210201	Тэтгэврийн даатгал	72,593,594.53	79,969,067.48
210202	Тэтгэмжийн даатгал	7,621,294.68	9,386,701.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,115,156.55	6,954,765.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,524,839.52	1,773,718.63

210205	Эрүүл мэндийн даатгал	15,246,894.90	18,027,914.24
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>200,591,549.60</b>	<b>219,512,551.75</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,355,405.00	12,067,900.00
210302	Түлш, халаалт	185,035,760.00	185,871,360.00
210303	Цэвэр, бохир ус	9,200,384.60	21,573,291.75
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,934,352.00</b>	<b>979,300.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,840,500.00	979,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,779,145.00</b>	<b>53,083,443.00</b>
210502	Хоол, хүнс	20,052,745.00	53,083,443.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,457,500.00</b>	<b>1,080,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,103,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	1,354,500.00	1,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>605,000.00</b>	<b>7,305,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	605,000.00	913,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,391,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,250,800.00</b>	<b>40,499,758.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,778,300.00	26,581,508.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,472,500.00	13,918,250.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,521,121.46</b>	<b>127,415,844.53</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,085,540.50</b>	<b>74,369,849.40</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,485,540.50	74,369,849.40
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>53,045,995.13</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	53,045,995.13
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>16,231,000.00</u></b>	<b><u>123,620,383.75</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,876,500.00</b>	<b>44,732,120.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,876,500.00</b>	<b>44,732,120.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>15,876,500.00</b>	<b>44,732,120.00</b>
222001	Тоног төхөөрөмж	13,351,500.00	44,732,120.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(15,876,500.00)</u></b>	<b><u>(44,732,120.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>354,500.00</b>	<b>78,888,263.75</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>78,888,263.75</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	-------	---

C0 1	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,003,170,165.12	298,116,019.02	915,977,488.06		2,217,263,672.20
C0 2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C0 3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,003,170,165.12</b>	<b>298,116,019.02</b>	<b>915,977,488.06</b>	-	2,217,263,672.20
C0 4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C0 5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C0 6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C0 7	Тайлант үеийн үр дүн	-	-	(64,532,851.87)		(64,532,851.87)
C0 8	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,003,170,165.12</b>	<b>298,116,019.02</b>	<b>851,444,636.19</b>	-	2,152,730,820.33
D0 1	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,003,170,165.12</b>	<b>298,116,019.02</b>	<b>851,444,636.19</b>	-	2,152,730,820.33
D0 2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D0 3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,003,170,165.12</b>	<b>298,116,019.02</b>	<b>851,444,636.19</b>	-	2,152,730,820.33
D0 4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D0 5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D0 6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D0 7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D0 8	Тайлант үеийн үр дүн	-	-	77,534,580.92		77,534,580.92
D0 9	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,003,170,165.12</b>	<b>298,116,019.02</b>	<b>928,979,217.11</b>	-	2,230,265,401.25

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	0.00	1221708500.00	1184957774.64
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	0.00	1221708500.00	1169081274.64
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	0.00	1189405700.00	1145995734.14
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.00	0.00	786302600.00	783985389.36
210101	Үндсэн цалин	0.00	0.00	526746200.00	525787388.36
210102	Нэмэгдэл	0.00	0.00	194820700.00	193904380.00
210104	Урамшуулал	0.00	0.00	64735700.00	64293621.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.00	0.00	104990700.00	103101780.18
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	73778700.00	72593594.53
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	7733000.00	7621294.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	6312400.00	6115156.55
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	1560600.00	1524839.52
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	15606000.00	15246894.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.00	0.00	207234400.00	200591549.60
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	8085900.00	6355405.00
210302	Түлш, халаалт	0.00	0.00	187883400.00	185035760.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	11265100.00	9200384.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	0.00	8935100.00	8750870.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00	483200.00	483120.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00	2922100.00	2883550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	679,400.00	650,000.00
210404	Ном, хэвлэл	-	-	386,700.00	270,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	1,450,500.00	1,450,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ажуйн эд зүйлс	-	-	3,013,200.00	3,013,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	-	40,031,100.00	23,779,145.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	592,800.00	592,200.00
210502	Хоол, хүнс	-	-	36,304,100.00	20,052,745.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	3,134,200.00	3,134,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	-	22,020,000.00	14,103,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-	20,300,000.00	13,103,000.00
210604	Урсгал засвар	-	-	1,000,000.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-	1,983,200.00	1,828,200.00
210702	Дотоод албан томилолт	-	-	1,983,200.00	1,828,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	-	820,200.00	605,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	820,200.00	605,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-	17,088,400.00	9,250,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	11,000,000.00	3,778,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	6,088,400.00	5,472,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	32,302,800.00	23,085,540.50
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-	32,302,800.00	23,085,540.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	-	31,702,800.00	22,485,540.50

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	600,000.00	600,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-	-	<b>15,876,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-	-	15,876,500.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	-	13,351,500.00
223001	Бусад хөрөнгө	-	-	-	2,525,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	1,221,708,500.00	1,215,065,649.60
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	1,013,474,100.00	1,013,474,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-	1,013,474,100.00	1,013,474,100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	208,234,400.00	201,591,549.60
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	208,234,400.00	201,591,549.60
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	<b>78,888,263.75</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	-	-	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	-	-	65.00	65.00
620001	Удирдах ажилтан	-	-	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	42.00	42.00
620003	Үйлчлэх ажилтан	-	-	22.00	22.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	-	-	654.00	654.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	-	-	654.00	654.00
630001	Төрийн өмчит ЕБС	-	-	654.00	654.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	-	-	<b>65.00</b>	<b>65.00</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	-	-	43.00	43.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	-	22.00	22.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгээгүй байна.

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн нь “Багшлахуй ба суралцахуйг дэмжье” гэсэн зорилгын доор таатай орчин, чанартай сургалт, шилдэг үйлчилгээг эрхэм зорилт болгон ажиллаж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, тогтоол шийдвэр, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулж, хэрэгжилт нь үр нөлөөтэй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудит, аудиторгүй дотоод хяналт шалгалтын ажилтантай тус хяналт нь улиралд нэг удаа үйл ажиллагааны хяналт шалгалтыг хийж байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.1 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	78,888,263.75	270,200
Авлага	13,000,000.00	0	13,000,000

Бараа материал	135,919,791.21	143,248,928.21	-7,329,137.00
Үндсэн хөрөнгө	2,003,811,029.12	2,008,712,318.29	-4,901,289.17
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,152,730,820.33</b>	<b>2,230,849,510.25</b>	<b>-78,118,689.92</b>
Өр төлбөр	0	584,109.00	584,109.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,003,170,165.12	1,003,170,165.12	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,152,730,820.33</b>	<b>2,230,849,510.25</b>	<b>-78,118,689.92</b>

Дээрх хүснэгтээс харахад, 2022 он өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн дансны талаар товч тайлбарлан бичнэ.

Нийт хөрөнгө буюу үндсэн хөрөнгө, бараа материалын дүн өссөн нь 16 сум нэг тосгоны хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудад МУ-ын БШУ-ны Сайдын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/494 тоот тушаалаар Цахим ангийг байгуулж 655-иас дээш хүүхэдтэй Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуульд 2 цахим ангийн тоног төхөөрөмж, хандиваар эмчийн өрөөний тоног төхөөрөмж зэрэг нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос нэмэгдсэн шалтгаанаар өөрчлөлт гарсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

МУ-ын БШУ-ны Сайдын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/494 тушаалын дагуу цахим анги тохижуулах "Хүүхдэд ээлтэй орчин" Тендер зарлаж "Тех но зон" ХХК шалгарч 0.9 сая төгрөгийн үнэтэй Tab8 25 ширэг, Notebook 2 ширхэг 5.9 сая, суурин компьютер 1 ширхэг 3.2 сая, Ухаалаг самбар 9.9 сая төгрөгөөр цахим дэлгүүрээс худалдан авалт хийжээ.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 667.01 сая, үйл ажиллагааны орлогоос 25.5 сая, нийт зарлагыг 692.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 716.8 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 24.3 сая төгрөгөөр бууруулж, 692.5 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч үндсэн хөрөнгө бэлтгэх саналыг хасаж баталсан шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 24.3 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрийн 38 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,279.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 1.6 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1609.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 53.04 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1562.5 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1640.1 сая, 53.04 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ /80226/	3715000	3715000	0	100
2	Сургалт семинар /80312/	1857500	1872782	31718	98.3
3	ЭМД шимтгэл /80823/	4272300	4268400	3900	99.9
4	Үдийн цай хөтөлбөр /81801/	82061900	74369840.4	7692050.6	91
5	Дотуур байрны үйлчилгээ /81806/	93735800	82762085.28	10973714.72	88.3

6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин /81816/	41960000	41542620	417680	99.1
7	Боловсролын байгууллагын багш /81823/	8358800	8358706	94	99.99
8	Боловсрол стандарт сургалт /81834/	924400800	869759894.42	54640905.58	94.1
9	Сургалтын хэвийн үйл ажиллагаа /81835/	118968100	114448000.15	4520099.85	96.3
10	Гүнзгийрүүлсэн төрөлжсөн /81844/	650000	650000	0	100
11	Сурах бичгийн түрээс /818848/	1971800	913400	1058400	13.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлангаар нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургууль дээр төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг Аудитын менежер Ж.Энхцоодол, Дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01/10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны бусад 16.1 сая төгрөгөөс 80 хувиар буюу 12.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бичиг хэргийн зардлыг өмнөх онтой харьцуулахад 2.4 сая төгрөгөөр хэмнэлт үүсгэж, 11 удаагийн сургалт семинарыг цахимаар зохион байгуулж үүнээс албан томилолтын зардал, шатахууны зардлыг хэмнэж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургууль нь өмнөх онд 4 мэдээлэл хоцроож санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж авсан бол 2022 онд Шилэн дансны 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дахь “Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй зөрчил илэрлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй зөрчил үүсээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомж, Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбогдох заалттай нийцээгүй тул албан шаардлага бичиж бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд Булагн аймгаг дахь Төрийн аудитын газарт санхүүгийн тайлангаа баталгаажуулж зөрчилгүй дүгнэлт авсан байна.

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тэшиг сумын ЕБС-ийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

*Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.*

*Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	0	0	0	0	0
<b>Нийт дүн</b>		<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхан шатны баримтын бүрдэлд анхаарч ажиллах, балансын урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд олгох, шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар явцад залруулсан алдаа<sup>1</sup> зөрчил үүсээгүй.

Аудитаар нийт 1.4 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 0.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Томилолтын зардлаас 0.2 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн.

2. Боловсролын Ерөнхий газрын 2022.06.20-ны өдрийн 1/643 албан тоотоор Тэшиг сумын ЕБС-ийн нярав нар 2 сарын үндсэн цалинг нярав 1.2 сая төгрөгийн урамшуулал авсан нь Төрийн албан хаагчид шагнал олгох журын 1 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.3 дахь "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэсэн заалтыг зөрчсөн тул 0.5 хувь буюу 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

#### 5.2 Албан шаардлага

1. Боловсролын Ерөнхий газрын 2022.06.20-ны өдрийн 1/643 албан тоотоор Тэшиг сумын ЕБС-ийн нярав 2 сарын үндсэн цалингаар 1.2 сая төгрөгийн балансын урамшуулал авсан нь Төрийн албан хаагчид шагнал олгох журын 1 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг зөрчсөн тул 0.8 сая төгрөгийн дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

2. Өмнөх оны санхүүгийн тайлангаар шилэн дансны 4 мэдээлэл хоцроож мэдээлсэн тул зөвлөмж авч байсан боловч 2022 онд шилэн дансны 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж өмнөх оны алдааг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүллээ.

#### 5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2023** оны **05** дугаар сарын **25**-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тэшиг сумын ЕБС	3	1,399.8	2	513.4	1	886.4						
Дүн	3	1,399.8	2	513.4	1	886.4						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
2022 онд Тэшиг сумын ЕБС нь шилэн дансны 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Өмнөх онд 4 мэдээлэл хоцроож зөвлөмж хүргүүлсэн байна.										
Дүн	1	0			1	0				